



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/167

Чингис хот

Ажлын хэсэг томлох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6"а", Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 2020 оны 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагатай махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, урамшуулал олгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Ц.Чогсомжав

Аймгийн Засаг даргыг орлогч

Нарийн бичиг:

Н.Ган-Адъяа

Хөрөнгө оруулалт, хөгжлийн
бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн

Гишүүд:

С.Нямдаваа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга

Ж.Энх-Амгалан

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Ж.Даваасүрэн

Иргэдийн төлөөлөл

2. Аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011967